

Мэргэжлийн болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, Д Батдорж

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх							
1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, сар бүр, хагас, бүтэн жилээр тайлагнах	Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд 2023 оны хагас, бүтэн жилд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн үр дүнгээр гарсан зөвлөмжийн биелэлтийг хангуулж ажилласан байна.	Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн Боловсролын салбарт 2024 онд хэрэгжүүлэхээр хяналтад авсан зүйл, заалтуудын хэрэгжилтэд 2023 оны жилийн эцэс, 2024 оны сар, улирал, хагас жилийн байдлаар тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэн https://new.unelgee.gov.mn/ цахим системд цаг тухай бүр нь тайлагнаж, баталгаажуулан ажиллаа. Хамгийн сүүлд Боловсролын салбарын Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 10 дугаар сарын хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын үнэлгээний нэгдсэн системд хугацаанд нь тайлагнасан. Нийт 246 заалтын хэрэгжилт үнэлэгдсэнээс 183 заалт бүрэн хэрэгжсэн буюу 100%, 56	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					<p>заалт хэрэгжих шатандаа буюу 70%, 4 заалтын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, 3 заалтын хэрэгжилт хангалтгүй үнэлэгдэж, дундаж хувь 92.19% ийн биелэлттэй байна. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас Боловсролын салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2023 оны жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ, хийж зөвлөмж ирүүлсэн боловч жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн мэдээллийг системд оруулаагүй. Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зохилгоор 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг 10 дугаар сарын байдлаар харьцуулж, бага хэрэгжилтийн хувь бага үнэлэгдсэн заалтуудын жагсаалтыг гаргаж, холбогдох нэгжүүдийн дарга, ахлах шинжээч нарт 10 дугаар сарын 30-ны өдөр И мэйлээр зөвлөмжийн хамт хүргүүлж ажилласан.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 2 файл</p>		
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах.	Зорилтын тоо, шалгуур	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн 2023 оны хагас, бүтэн жилийн тайлан	Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн үр дүнгээр гарсан зөвлөмжийн биелэлтийг хангуулж ажилласан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Боловсрол, шинжлэх ухааны салбарын чиглэлээр 4 зорилтын хүрээнд 96 арга хэмжээ тусгагдсанаас 2024 оны эхний хагса жилийн байдлаар зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан 100%-ийн биелэлттэй-57, зорилт, арга хэмжээний	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн

					хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа 90,0%-ийн биелэлттэй-22, тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа 70%-ийн хэрэгжилттэй-12, тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн 50%-ийн хэрэгжилттэй-4, тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа 30%-ийн хэрэгжилттэй-1, ажил гэж тус тус үнэлэгдсэн. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд холбогдох санал өгч ажиллаа.		хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах.	Зорилтын тоо, шалгуур	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн 2023 оны хагас, бүтэн жилийн тайлан	Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн үр дүнгээр гарсан зөвлөмжийн биелэлтийг хангуулж ажилласан байна.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан боловсрол, шинжлэх ухааны салбарын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино. Хяналтад авсан арга хэмжээнүүдийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа

					<p>явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д боловсрол, шинжлэх ухааны салбарт хамаарах нийт 4 зорилго, 5 зорилтын хүрээнд 24 арга хэмжээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 100%-тай үнэлэгдэж байгаа нь 2022 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээнээс 0.42%-иар өссөн үзүүлэлттэй байна.БШУЯ-ны хувьд бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, үр дүнг сайжруулахын тулд 2023 оны хагас 2 дугаар улирлаас эхлэн яамны харьяа болон нэгж байгууллагуудад хугацаатай үүрэг өгч, биелэлтийг сар бүр тооцож ажилласан. Үүний үр дүнд “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан боловсрол, шинжлэх ухааны салбарт хамаарах 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээ хангалттай хэрэгжсэн гэж дүгнэгдлээ.</p>		гүйцэтгэсэн байдал: 100%
4	Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ,	Арга хэмжээний тоо болон хэрэгжилтийн хувь	Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ,	Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн үр дүнгээр гарсан зөвлөмжийн	Боловсрол, шинжлэх ухааны яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт болон сургалт, ажиллах нөхцөл, нмйгмийн баталгааг хангах хөтөлбөр, ил тод байдлын шалгуур үзүүлэлт зэргийн хэрэгжилтэд хяналт-	3-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	үнэлгээ хийж тайлагнах. /Хавсралт тайлангууд/		үнэлгээ хийсэн 2023 оны хагас, бүтэн жилийн тайлан	Биелэлтийг хангуулж ажилласан байна..	шинжилгээ, үнэлгээ хийж, https://new.unelgee.gov.mn/planhumanres/ цахим системд байршуулсан. Хавсралт: 2 файл		үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
5	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах.	Зорилтын тоо, шалгуур	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн 2023 оны жилийн эцсийн тайлан	Хяналт-шинжилгээ үнэлгээний тайланг холбогдох газарт хугацаанд нь хүргүүлсэн байна.	Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэн https://new.unelgee.gov.mn/ системд байршуулсан. Мөн холбогдох тайлан мэдээллийг ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд Боловсрол, шинжлэх ухааны яаманд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг 5 газар 6 хэлтэс тус бүр чиглэлийн дагуу гаргахад зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан 100%-ийн биелэлттэй-20, 90%-ийн биеэлтэй-1, тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					<p>шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа 70%-ийн хэрэгжилттэй-1ажил гэж тус тус үнэлэгдсэн.Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд жилийн эцсийн байдлаар 97.5%-ийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх онтой харьцуулахад 3.8%-иар өссөн үзүүлэлттэй байна. Салбарын хувьд 2023 оны 9 дүгээр сараас эхлэн хэрэгжилтэд дүгнэлт хийн хангалтгүй арга хэмжээг эрчимжүүлэх үүргийг нэгжүүдэд өгч үр дүнг тооцон ажилласан.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 2 файл</p>		
6	Боловсрол, шинжлэх ухааны сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Зорилтын тоо, шалгуур	Боловсрол, шинжлэх ухааны сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн 2023 оны жилийн эцсийн тайлан	Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийг хүргүүлсэн байна.	Боловсролын сайдын аймаг, нийслэлийн засаг дарга нартай байгуулсан гэрээний 2024 оны эхний хагса жилийн биелэлтийн тайланд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан. Эхний хагас жилийн байдлаар хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээг эрчимжүүлэх зөвлөмжийг аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар, боловсролын газруудад хүргүүлсэн.	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал:

							100%
1.2. Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, төсөв, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, аюулгүй байдал, харьяа байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод аудит явуулах, дүгнэлт, зөвлөмж гаргах							
7	Харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх.	Үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн чанар, үр дүн	2023 оны үйл ажиллагааны тайлан	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан байна.	2023 оны жилийн эцсийн байдлаар Боловсрол, шинжлэх ухааны салбарын харьяа байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон. Байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй танилцаж, тайланг сонсож, өөрийн зүгээс үнэлгээ өгч ажилласан. Энэ онд ажлын хэсэг байгуулагдаагүй байна. Хугацаа болоогүй.	11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
8	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургууль, дотоор байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих үйл ажиллагаа, гүйцэтгэл, үр дүнд хяналт-шинжилгээ, дотоод аудит	Үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн чанар, үр дүн	2023 оны үйл ажиллагааны тайлан	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг хийж, нэгдсэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан байна.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргын баталсан удирдамжийн дагуу 01 дүгээр тогтоолын хэрэгжилт болон Увс аймагт хэрэгжиж буй нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих төсөл арга хэмжээний ажлын явц, гүйцэтгэлтэй танилцах, үр дүнг газар дээр нь хянах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал дүгнэлт боловсруулахад ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 10-ны өдрийг дуусталх хугацаанд буюу нийт 11 хоногт хийж гүйцэтгэлээ.	5-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн

	хийх				<p>Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга, Улсын их хурлын гишүүн Б.Баярсайхан, Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын ахлах мэргэжилтэн Д.Батдорж, Боловсролын ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын газрын Захиалагчийн хэлтсийн мэргэжилтэн Л.Төртогтох, Барилгын хөгжлийн төвийн Барилга байгууламжийн Захиалагчийн хэлтсийн хяналтын инженер Б.Дагва, хяналтын инженер Т.Бат-Эрдэнэ, орон нутгийн байгууллагын холбогдох албан хаагчдыг төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг ажиллалаа. Тус ажлын хүрээнд Увс аймгийн нийт 19 сумын 60 объект хамруулан ариун цэврийн байгууламжийн ажлын явцтай газар дээр нь танилцаж, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд шуурхай арга хэмжээ авч ажилласан. Ажлын нэгдсэн тайланг боловсруулж, удирдлагад танилцуулсан. Тус газрын ахлах шинжээч Б.Доржхуягтай хамтран нэгдсэн тайлан, танилцуулгыг боловсруулсан.</p> <p>Хавсралт: 1 файл</p>		байдал: 100%
9	Орхон аймаг дахь Политехникийн коллежийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүн	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан байна.	Боловсролын сайдын 2024 оны А/39 дүгээр тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу Орхон аймгийн Политехник коллежийн зарим үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг газар дээр нь зохион байгуулж. Боловсролын сайдын А/39 дүгээр тушаалаар ажлын хэсгийн гишүүнээр томилогдож, тус коллежийн	8-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн

					зарим багш нараас ирүүлсэн өргөдөл гомдолд дурдсан асуудлыг газар дээр нь судлан үзэж, шаардлагатай зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх, зөвлөгөө зөвлөмж өгөх, зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан талаарх тайлан, дүнгэлтийг боловсруулж Боловсролын сайдад танилцуулж ажиллалаа. Хяналт шалгалтын үр дүнд сургуулийн удирдлага болон гомдол гаргач багш нар нэгдсэн ойлголцолд хүрч, ажлын хэсгээс өгсөн зөвлөгөө зөвлөхийг хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдлээ. Хавсралт: 1 файл		даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	--	--	--

3.1. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх

10	Боловсролын ерөнхий хууль болон түүнийг дагалдан шинээр батлагдсан хуульд тусгагдсан Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хүрээнд батлах журмуудад санал өгөх, хяналт тавьж ажиллах	Хэрэгжилтийн хувь	-	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх хүрээнд батлах журмуудад хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр санал өгч, хяналт тавьж ажилласан байна.	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх хүрээнд батлах журмуудад хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр санал өгч, тогтмол хяналт тавьж ажилласан. Боловсролын багц хуульд шинээр болон шинэчлэн батлагдахаар тусгагдсан Салбарын хэмжээнд мөрдөгдөх Хэм хэмжээний акт, эрх зүйн актын жагсаалтыг БШУС-ын 2023 оны А/331 дугаар тушаалаар баталсан. Тус тушаалын хэрэгжилтийг нэгтгэн, хэрэгжилтийн явцад дүн шинжилгээ хийх, удирдлагад танилцуулах, эрчимжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, тухай бүр хэрэгжилтийн явцын талаар танилцуулга боловсруулж ажилласан. Мөн ХЗДХЯ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу 2024 оны 6, 10 дугаар саруудад эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй байгаа Боловсролын салбарын хэм хэмжээний	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
----	--	-------------------	---	---	---	-------------------------------------	---

					актын хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайлан болон цаашид авч хэрэгжүүлэх санал дүгнэлтийн ХЗДХЯ-нд хүргүүлж ажилласан болно. Хавсралт: 4 файл		
11	Яаманд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт шалгалт хийж, зөвлөмж хүргүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	-	Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан байна.	Боловсролын яаманд хандан иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлын хэрэгжилтийн мэдээллийг ТЗУГ-аас гаргуулан авч, хугацаа хоцорсон, хариу өгсөн, хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ хийж, сайдын шуурхай хуралдаанд танилцуулсан. Өргөдөл гомдлыг цаг тухайд нь шуурхай шийдвэрлэх талаар зөвлөмж хүргүүлж ажилласан. Энэ оны 12 сарын 5-ны өдрийн байдлаар нийт 41 албан бичиг, 26 өргөдөл гомдлыг судалж хариу өгөх үүргийг удирдлагаас өгсөн бөгөөд. Нийт хэрэгжилтийн тайлан, мэдээлэл, хяналт шалгалтын дүн, санал хүргүүлэх тухай 32 хариу албан бичгийг төлөвлөн боловсруулж ажилласан байна.	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
12	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг цахим системд байршуулах, сан үүсгэх	Хэрэгжилтийн хувь	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангуудыг мэдээллийн системд байршуулсан байна.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт болон бусад бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланд сар, улирал, хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тухай бүр нь Засгийн газрын үнэлгээний нэгдсэн системд тайлагнаж, мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн

							хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
13	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу аливаа хуралт, уулзалтыг зохион байгуулах, салбарын чиглэлээр холбогдох тайлан мэдээ, санал дүгнэлтийг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх	үүрэг даалгаврын биелэлтийн хувь	-	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу аливаа хуралт, уулзалтыг зохион байгуулах, салбарын чиглэлээр холбогдох тайлан мэдээ, санал дүгнэлтийг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлсэн байна	Аймаг, нийслэлийн Боловсролын газрын хяналт-шинжилгээ, хариуцсан мэргэжилтнүүдийн дунд хяналт-шинжилгээ, дотоод аудитын чиглэлээр сургалтыг зохион байгуулсан. Тус сургалт нь 2024 оны 3 дугаар сарын 10-ны өдөр Туушин ххк-ийн хурлын танхимд явагдсан бөгөөд сургалтаар хяналт-шинжилгээ, үнэлгээний журмын танилцуулга, дотоод аудитын анхаарах асуудал, байгууллагын менежмент зэрэг чиглэлүүдээр илтгэл тавигдсан. Мөн “Eduten”, “Pearson” хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, илэрсэн зөрчлийг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах удирдамжийг хэлэлцэн баталж, аймаг нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газрын холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлэн хяналт-шинжилгээ хийгдсэн. УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар санал солилцохоор Ерөнхийлөгчийн тамгын газрын төлөөлөл Боловсролын сайд П.Наранбаяртай уулзах уулзалтын зохион байгуулалтыг хангаж, холбогдох тайлан танилцуулгыг нэгтгэн боловсруулсан. Мөн тус тогтоолын хэрэгжилтийн талаар Төрийн байгууллагуудын зөвлөлдөх уулзалт	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					<p>Төрийн ордонд 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан. Тус хуралдаанд Боловсролын яамны ТНБД Х.Батжаргал оролцож “ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙН ХҮНИЙ НӨӨЦ, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ БОЛОН_Х000В_СУРГУУЛИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ” сэдвээр илтгэл тавьсан. Хуралдааны бэлтгэл ажлын зохион байгуулалтыг хариуцаж ажилласан бөгөөд Ерөнхийлөгчийн тамгын газраас Боловсролын яамны танилцуулга маш сайн боллоо гэж дүгнэсэн.</p> <p style="text-align: right;">Хавсралт: 4 файл</p>	
--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Эрхлэх асуудлын хүрээнд шаардлагатай	Эрхлэх асуудлын хүрээнд шаардлагатай	-	Эрхлэх асуудлын хүрээнд шаардлагатай	Албан тушаалын чиг үүргийн хүрээнд болон, салбарын чиглэлээрх хууль тогтоомж,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р	Өөрийн үнэлгээ: 100%

	хууль, журмыг судлах	дүрэм уншиж	хууль, журмыг судлах, олондоо туслах	дүрэм уншиж хамт зөвлөн		хууль, журмыг судлах, олондоо туслаж ажигласан байна.	дүрэм уншиж хамт зөвлөн	дүрэм журмыг тогтмол судалж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн яамны зүгээс зохион байгуулж буй мэдээллийн цагт тогтмол хамрагдаж байна. Боловсролын салбарын хэм хэмжээний акт, эрх зүйн актын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, хяналт-шинжилгээ хийж, нэгдсэн танилцуулга, тайлан боловсруулж, удирдлагад танилцуулж ХЗДХЯ зэрэг байгууллагад хүргүүлж ажиллаа. Хавсралт: 2 файл	сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ: 90%
2	Ажлын байран дахь тасралтгүй хөгжлийг хангах үүднээс чиг үүргийн дагуу холбогдох сургалтад хамрагдах	Ажлын байран дахь тасралтгүй хөгжлийг хангах үүднээс чиг үүргийн дагуу холбогдох сургалтад хамрагдах	-	Ажлын байран дахь тасралтгүй хөгжлийг хангах үүднээс чиг үүргийн дагуу холбогдох сургалтад хамрагдсан байна.		Ажлын байран дахь тасралтгүй хөгжлийг хангах үүднээс чиг үүргийн дагуу холбогдох сургалтад хамрагдсан байна.	Ажлын байран дахь тасралтгүй хөгжлийг хангах үүднээс дээд шатны байгууллага, Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан сургалт, яамны мэдээллийн цагаар явагддаг сургалтуудад тогтмол хамрагддаг. Мөн 8 дугаар сард Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хяналт-үнэлгээ хийх" сэдэвт сургалтад хамрагдаж, холбогдох мэдээллийг нэгжийн даргад танилцуулсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85%	
3	МУБИС-д Боловсрол судлалын	МУБИС-д Боловсрол судлалын	МУБИС-д Боловсрол судлалын	хичээл	МУБИС-д Боловсрол судлалын	МУБИС-ын Боловсрол судлалын Боловсролын удирдлагын	Боловсрол сургуульд	11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 70%	

	чиглэлээр суралцаж магистрын зэрэг, урьдчилсан байдлаар хамгаалах.	чиглэлээр суралцаж магистрын зэрэг, урьдчилсан байдлаар хамгаалах.		чиглэлээр суралцаж магистрын зэрэг, урьдчилсан байдлаар хамгаалсан байна.	магистрын хөтөлбөрөөр суралцаж байгаа бөгөөд бүх кредитийг судалж дуусгасан. Энэ оны 12 дугаар сарын сүүлээр урьдчилсан хамгаалалт хийхээр удирдагч багш /МУБИС-ын ЕБС-ын захирал профессор М.Мөнхбаатар/-тай зөвлөлдөж, хамгаалах сэдвээ тохироод байна.		Нэгжийн даргын үнэлгээ: 85%
--	--	--	--	---	---	--	-----------------------------

ТАЙЛАН ГАРГАСАН:

Мэргэжлийн болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, Д Батдорж
 /...../ Огноо: